



**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 07

Чойр

**Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг  
2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл  
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19.1, 22 дугаар зүйлийн 22.1.11, 25 дугаар зүйлийн 25.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнахыг аймгийн Засаг дарга /Г.Батсуурь/-д даалгасугай.

ДАРГА



Г.БАТЗАМ

Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 04 ний өдрийн 09 дүгээр хуралдааны 07 дугаар тогтоолын хавсралт



**Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл**

№	Дунд зорилт хугацааны	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүн	Шаардагдах хөрөнгө, эх үүсвэр /сая.төг/	Хариуцах байгууллага
<b>НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ</b>						
1	Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ.	Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна.	Төсвийг үр ашигтай зарцуулж, төсвийн сахилга батыг хангаж ажилласан байна.	Зөрчил гараагүй байна.	-	АЗДТГ, СЗДТГ
2		Орон нутгийн хөгжлийн санг иргэдэд ил тод нээлттэй болгож, зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ.	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээг иргэдээр эрэмбэлүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. Орон нутгийн хөгжлийн санг журмын дагуу зарцуулж, үр дүнг олон нийтэд тайлагнана. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, бүртгэлд бүрэн хамруулна.	Нийт өрхийн 55 хувь  2 удаа  100 хувь	-	АЗДТГ, СЗДТГ, ОНӨГ
3		Татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэн, татварын орлогыг нэмэгдүүлж, улс, орон нутгийн татварын орлогыг бүрдүүлнэ.	Улсын болон орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт	100 хувь	-	ТХ
4	Бизнесийн таатай орчин бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг зээлийн бодлогоор дэмжинэ.	Хуулийн хүрээнд шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг олгоно.	Хяналт шалгалтыг цөөрүүлж, зөвлөн туслах үйл ажиллагааг эрчимжүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулна.	Зөрчлийг өмнөх оны үзүүлэлтээс 70 хувиар бууруулна.	-	АЗДТГ, СЗДТГ
5		Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 28.0	АЗДТГ
6		ЖДҮДС, СХСангийн зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	Бий болсон байнгын ажлын байрны тоо Хуваарийн дагуу төлөгдсөн эргэн төлөлт	50 100 хувь	ЖДҮДС, СХС	СЗДТГ, ХХААГ
<b>2. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ</b>						
<b>2.1 Худалдаа, үйлчилгээний салбар</b>						
7	Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.	Орон нутгийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.	Тохирлын гэрчилгээтэй аж ахуйн нэгжийн эзлэх хувь Зохион байгуулсан сургалтын тоо	100 хувь  5	-	АЗДТГ
<b>2.2 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн салбар</b>						
8	Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангах.	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачлагыг зээлийн болон газрын бодлогоор дэмжих.	Байгуулагдсан цехийн тоо	1	СХС 30.0	СЗДТГ, ХХААГ
9		Стандартын шаардлага хангасан зоорь, агуулахын тоог нэмэгдүүлэх.	Засварласан агуулах, зоорийн тоо Агуулахаас зах зээлд нийлүүлэх махны хэмжээ Агуулахаас зах зээлд нийлүүлэх төмс, хүнсний ногооны хэмжээ	1  142.6 тн  80.8 тн	1  СХС 10.0	СХС 10.0

10		Мал нядалгааны цех байгуулахад зээлийн болон газрын бодлогоор дэмжих.	Бий болсон цехийн тоо	1	ХХО	СЗДТГ, ХХААГ	
11		Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг сайжруулна.	Төлөвлөгөөт шалгалтын тоо	4	ОНТ	ХХААГ, МХГ	
<b>Мал аж ахуйн чиглэлээр</b>							
12	Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлэх.	Цөм сүргийг бүртгэлжүүлж, гарал үүслийг тодорхой болгож, бүс нутгийг шийдвэрлэнэ.	Ангилалт, баталгаажуулалтанд хамрагдсан хээлтүүлэгчийн эзлэх хувь	100 хувь	ОНТ 6.2	Сумдын МЭҮТ, МҮНэгж	
Эмэгжүүлэлт, ангилалт, баталгаажуулалтанд хамрагдсан хээлтэгчийн эзлэх хувь			10 хувь				
Бүс нутгийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, шийдвэрлэгдсэн байна.			100 хувь				
13	Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах.	Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах.	Шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо	2	Сумдын ОНХС, УТХО 30.0 ХХО	ХХААГ	
Засварлах худгийн тоо			2				
Олон наст ургамал тариалах талбайн хэмжээ			30 га				
14	Малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, малчдыг сургалтанд хамруулж, туршлага судлуулж, сайн туршлагыг нэвтрүүлнэ.	Малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, малчдыг сургалтанд хамруулж, туршлага судлуулж, сайн туршлагыг нэвтрүүлнэ.	Малжуулсан өрхийн тоо	10	-	АЗДТГ, СЗДТГ	
Малын тоо			500				
Зохион байгуулсан сургалтын тоо			3				
15	Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Каракуль арьсны чиглэлийн Сүмбэр үүлдрийн хонины удмын санг хамгаалж, тоо толгойг өсгөнө.	Зохиомол хээлтүүлэгт орох хээлтэгчийн эзлэх хувь	100 хувь	ОНТ	ХХААГ, Сүмбэр хонь ОНӨҮГ	
Зохиомол хээлтүүлгийн үр дүн			85 хувиас багагүй				
16	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, бодлогоор дэмжиж, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.	Эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, бодлогоор дэмжиж, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлнэ.	Зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	5	ЖДҮДС 75.0	ХХААГ	
Зохион байгуулагдсан сургалтын тоо			1-ээс доошгүй				
17	Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх.	Мал эмнэлгийн лабораторийн барилгыг шийдвэрлэж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Лабораторийн хэвийн ажиллах нөхцөл бүрдэнэ.	-	УТХО	ХХААГ	
18			Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх.	Мал, амьтны ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хэрэгжүүлнэ.	100 хувь	ОНТ 19.5	ХХААГ
19				Мэргэжлийн байгууллагуудтай хамтран шинээр гарч байгаа халдварт өвчний тандалт, судалгаа хийгдсэн байна.	2	ОНТ 3.0	ХХААГ
20				Мал эмнэлгийн нэгжүүдийг дэмжиж, малын эм тарианы зохистой хэрэглээг нэвтрүүлж, хяналт тавина.	Зохион байгуулах сургалтын тоо	2	-
	Зах зээлд борлуулагдаж буй малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтын тоо	4					
<b>Газар тариалангийн чиглэлээр</b>							
21	Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх санаачлагыг дэмжиж нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлнэ.	Эргэлтийн талбайн хэмжээ	80.0 га	ХЭДС СХС 4.5	ХХААГ	
22			Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлнэ.	Талбайн ашиглалт			70 хувь
23				Нэгж ургацын хэмжээ			70 цн/га
24			Чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалахыг дэмжинэ.	Тариалах талбайн хэмжээ			0.5 га

Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр						
25	Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний чанарыг сайжруулж, борлуулалтыг дэмжинэ.	Үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах шинээр байгуулсан цэгийн тоо Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулна. Зохион байгуулах үзэсгэлэн худалдааны тоо	1 2	ЖДҮДС, АОНХС	ХХААГ, ХХҮГ
2.3 Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар						
26	Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Шивээ-Овоогийн нүүрсний ордыг түшиглэн хэрэгжүүлэх төслүүдийг бодлогоор дэмжинэ.	Шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж хамтран ажилласан байна. Газрын бодлогоор дэмжиж хамтран ажилласан байна.	-	ХХО	АЗДТГ
27		Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааг дэмжинэ.	1-ээс дээш аж ахуй нэгж түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын ажлыг эхлүүлэн орон нутгийн хайрга, дайрганы хэрэгцээг хангах.	20 хувь	ХХО	АЗДТГ
28		Барилгын материалын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.	Явган замын хавтан, хөнгөн блокн үйлдвэрийн тоо	1	ХХО	АЗДТГ
2.4 Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, дэд бүтцийн салбар						
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр						
29	Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлэх.	Иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	Газар өмчлөх иргэдийн тоо	1000	-	ГХБХБГ, Сумдын ЗДТГ
30		Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн, батлуулж, мөрдөж эхлэнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	-	АЗДТГ, ГХБХБГ
31		Сумдын төвийн айл өрх, албан байгууллагуудыг хаягжуулна.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	Сумдын ОНХС 10.0	ГХБХБГ, Сумдын ЗДТГ
32		Газрын биржийн цахим системийн үйл ажиллагааг сайжруулна.	Газрын биржийн цахим системээр газар өмчлөл, эзэмшил, төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдааг зохион байгуулна.	100 хувь	-	ГХБХБГ, Сумдын ЗДТГ
33		Иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтын газрын эрхийн болон үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг шинэчлэх, солих ажлыг эхлүүлнэ.	Газрын гэрчилгээ шинэчлэлтийн хувь	10 хувь	ОНТ	ГХБХБГ, Сумдын ЗДТГ
			Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээний шинэчлэлтийн хувь	10 хувь		
34		Аймгийн төвд цэвэрлэх байгууламж байгуулахад шаардагдах төсвийг шийдвэрлүүлнэ.	Төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн байна.	-	-	АЗДТГ, ГХБХБГ
35		Тохижилт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 13.0	АЗДТГ, БОАЖГ
36		Соёл, спорт амралтын хүрээлэнгийн тохижилтын ажлыг үргэлжлүүлнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 100.0	АЗДТГ, ГХБХБГ
37		Сүмбэр сумын 1 дүгээр багийн Төмөр замын хэсгийн айл өрхийг бохирыг төв цэвэрлэх байгууламжид холбоно.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	Төсөл хөтөлбөр 350.0	АЗДТГ, ГХБХБГ
38		ШШГА-ны 75 айлын орон сууцны барилгын гадна фасадыг засварлана.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 60.0	АЗДТГ, ГХБХБГ
39	Хаус хороолол барих ажлыг бодлогоор дэмжинэ.	Хаус хорооллын ерөнхий төлөвлөгөө, зураг төсөв боловсруулагдаж газар олгогдсон байна.	-	ХХО	АЗДТГ, ГХБХБГ	
40	Төмөр замын нийтийн орон сууцнуудын барилгын дээвэр засварлана.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	Сумын ОНХС 60.0	АЗДТГ, ГХБХБГ	
41	Нийтийн эзэмшлийн талбайг тохижуулна.	Тохижуулах талбайн тоо	4	АОНХС 400.0 Төсөл, хөтөлбөр	АЗДТГ, ГХБХБГ	

42		Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулна.	Иргэдийн идэвх санаачлагаар засварлагдсан орцны тоо Шинээр байгуулах нийтийн бие засах газрын тоо Шинээр хийх хайсын хэмжээ	10 2 2000 м	ХХО, Сумдын ОНХС 50.0	АЗДТГ, ГХБХБГ
43		Аймгийн татварын хэлтсийн барилгыг ашиглалтанд оруулна	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 700.0	АЗДТГ, ГХБХБГ, Татварын хэлтэс
44		Цагдаагийн хэлтсийн барилгын их засварын ажил	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 166.0	АЗДТГ, ГХБХБГ, Цагдаагийн хэлтэс
45		Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга	Ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 100.0	АЗДТГ, ГХБХБГ,
46	Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангах.	Сумдын гэр хорооллын ус түгээх байрыг шинээр барьж, засварлах.	Засварласан худгийн тоо	3-ээс доошгүй.	Сумдын ОНХС 30.0	СЗДТГ, ГХБХБГ, ОНӨҮГ
<b>Эрчим хүчний чиглэлээр</b>						
47		Найрамдал хотхоны байрнуудын өмнөх 2.3 км шугам, Сүмбэр сумын 3 дугаар багаас Тэрэгтийн худаг хүртэл татсан 18 км хос шугамыг зөөвөрлөж, шилжүүлнэ.	Зөөвөрлөх шугамын урт	20.3 км.	УТХО 230.0	ГХБХБГ, ЦТС ТӨХК
48	Цахилгаан, дулааны эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах.	Аймаг, сумдын төвд иргэдийн өмчлөлд шинээр олгосон газруудын цахилгаан хангамжийг шийдвэрлэнэ.	Сүмбэр сумын өмчлөлд олгосон газруудад 6кВт-ын шугам татаж, КТПН байгуулж, цахилгаанд холбоно.	100 хувь	УТХО 607.5	АЗДТГ, СЗДТГ, ГХБХБГ, ЦТС ТӨХК
49		Аймгийн төвд дулааны станц барих ажлын ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулна.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	-	АЗДТГ, ГХБХБГ
50		Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг бий болгож, салхин болон нарны цахилгаан станц байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.	Хөрөнгө оруулалтын ажлыг дуусган эрчим хүч үйлдвэрлэж эхэлсэн байна.	100 хувь	ХХО	ГХБХБГ, СЗДТГ
51		Хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлнэ.	Хийн түлшээр ажилладаг авто машины тээврийн хэрэгсэлд эзлэх хувь	Өмнөх оноос нэмэгдсэн байна.	ХХО	Хувийн хэвшил
<b>Зам тээврийн чиглэлээр</b>						
52		Ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн төвд барих авто замын зураг төсвийг боловсруулж, 4 замын уулзварт шинээр гэрлэн дохио хийнэ.	Гэрлэн дохио	1	АЗС 50.0	АЗДТГ, ГХБХБГ
53		Нийтийн эзэмшлийн талбайд явган зам, гэрэлтүүлгийн ажлыг үргэлжлүүлэн хийнэ.	Шинээр тавьсан явган замын талбай Шинээр хийгдсэн гэрэлтүүлгийн тоо	1500 м2 50 ш	АОНХС 100.0	СЗДТГ, ГХБХБГ
54	Орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөж, засварлах.	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг чадавжуулж явган болон авто замын засвар арчлалтыг сайжруулж, тоног төхөөрөмжөөр хангана.	Явган болон авто зам, тохижилтын засварын ажлыг ОНӨҮГазрууд гүйцэтгэх чадавхтай болсон байна. Үүрдэг хогийн савны тоо	100 хувь 5 ш	Сумдын ОНХС 12.5	ОНӨҮГ
55		Аймгийн төвд авто пүү байршуулах ажлыг хувийн хэвшилд тулгуурлан байгуулна.	Стандартын шаардлага хангасан авто пүү байршуулж, авто замын хяналтыг сайжруулсан байна.	1 ш	ХХО	Аймгийн цагдаагийн хэлтэс, Авто тээврийн үндэсний төв

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО						
3.1 Эрүүл мэндийн салбар						
56	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх.	Эрүүл мэндийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	АЗДТГ, ЭМГ
57		190 ортой нэгдсэн эмнэлгийн шинэ барилгын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 500.0	АЗДТГ, ГХБХБГ, ЭМГ
58		Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, нялхсын эндэгдлийг бууруулна.	Төрөх тасгийг эх, нярайн нэг удаагийн цомгоор хангана. Нялхсын эндэгдлийн суурь түвшин өмнөх оноос буурсан байна.	100 хувь	Сумдын ОНХС 5.0	СЗДТГ, ЭМГ
59		Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдийг зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд шаардлагатай оношлуур, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үргэлжлүүлнэ.	Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдалтын хувь	15-аас дээш хувиар нэмэгдсэн байна.	Сумдын ОНХС 15.0	СЗДТГ, ЭМГ
60		Аймгийн нэгдсэн эмнэлгийн их засварын ажлыг хийнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 67.5	АЗДТГ, ЭМГ
3.2 Боловсрол, соёл урлаг, спортын салбар						
Боловсролын чиглэлээр						
61	Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах.	Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 30.0	АЗДТГ, БСУГ
62		Сүмбэр сумын 100 хүүхдийн Канад загварын цэцэрлэгийг ашиглалтад оруулна.	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 482.0	АЗДТГ, БСУГ
63		2-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын ажлыг эхлүүлнэ.	Зураг төсвийн гүйцэтгэл Ажлын гүйцэтгэл	100 хувь 10 хувь	Төсөл, хөтөлбөр 5280.0	АЗДТГ, БСУГ
64		Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн хуучин барилгын их засварын ажлыг хийж гүйцэтгэнэ.	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	Төсөл хөтөлбөр 234.0	АЗДТГ, БСУГ
65		Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн хашаа, тоглоомын талбайн тохижилтыг хийнэ. /Аяганы хонхор/	Барилга, тохижилтын ажлын гүйцэтгэл	100 хувь	ОУБ АОНХС 30.0	АЗДТГ, БСУГ
66		Баянтал сумын 4 дүгээр сургуулийн спорт заалны дээвэр засварын ажлыг хийнэ.	Барилгын ажлын гүйцэтгэл	100 хувь	Сумын ОНХС 15.0	АЗДТГ, БСУГ
67		Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын холболтын зураг төсвийг хийлгэнэ.	Зураг төсвийн ажлын гүйцэтгэл	100 хувь	Сумын ОНХС 15.0	АЗДТГ, БСУГ
68		Сургуулиудын ширээ, сандлыг шинэчлэн сайжруулна.	Шинэчлэх ширээ сандлын тоо	375	Сумдын ОНХС 60.0	АЗДТГ, БСУГ
69		Цэцэрлэгийн тоглоом, зөөлөн эдлэлийг сайжруулна.	Зөөлөн эдлэл сайжруулсан цэцэрлэгийн тоо	1	Сумдын ОНХС 5.0	АЗДТГ, БСУГ
70		Хувийн хэвшлийн цэцэрлэг шинээр байгуулахыг бодлогоор дэмжинэ.	Газрын болон зээлийн бодлогоор дэмжинэ.	-	ХХО ЖДҮДС	АЗДТГ, БСУГ
Соёл урлаг, спортын чиглэлээр						
71	Соёл, урлагийн байгууллагуудын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх.	Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 47.5	АЗДТГ, БСУГ
72		Аймгийн номын санг номоор хангана.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 5.0	АЗДТГ, БСУГ
73		Боржигин морин хуур, боржигин уртын дууны сургалтыг зохион байгуулна. Боржигин морин хуураар хангана.	Морин хуурын тоо	36-аас доошгүй	АОНХС 18.0	АЗДТГ, БСУГ

74	Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлэх.	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	УТХО 16.0 АОНХС 25.0	АЗДТГ, БТСГ
75		Биеийн тамир, спортын цогцолбор байгуулах ажлын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	Төсөл, хөтөлбөр	АЗДТГ, БТСГ, ГБХББГ
76		Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 25.0	АЗДТГ, БТСГ
<b>3.3 Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар</b>						
<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр</b>						
77	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр болон хувийн бизнес эрхлэх чадамжийг бий болгож, ажилгүйдлийг бууруулах.	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, ажилгүйдлийг бууруулна.	Байнгын ажлын байрны тоо Түр ажлын байрны тоо	200 200	ХЭДС	ХХҮГ
78		Зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилчдын хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулна.	Нийгмийн даатгалд хамрагдалтын хувь Сайн дурын даатгалд хамрагдалтын хувь	100 хувь 100 хувь	-	
79	Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулах.	Зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 18.0	ХХҮГ, ГБХЗХГ
80		Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 10.0	ХХҮГ, ЭМГ
81		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулна.	Шинээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудын дэд бүтцийг асуудлыг шийдвэрлэсэн байна.	100 хувь	ОНТ	ГБХЗХГ
82		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	Өмнөх оноос 20 хувиар нэмэгдүүлнэ	-	ГБХЗХГ
<b>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр</b>						
83	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	Нийтийн тээврийн үйлчилгээг бодлогоор дэмжинэ.	Шинээр бий болох нийтийн тээврийн хэрэгслийн тоо Зорилтот бүлгийн гишүүдийг хөнгөлөлттэй үнээр тээвэрлэнэ.	1 -	АОНХС 80.0 ОНТ 2.5	АЗДТГ, ГБХЗХГ
84		Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 16.0	ГБХЗХГ
<b>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>						
<b>4.1 Байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр</b>						
85	Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх.	Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулна.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 20.0	УЦУОШ А
86		Цаг агаарын урьдчилсан мэдээ, дулаан хүйтний улирлын төлөв, аюулт үзэгдлийн сэрэмжлүүлэх мэдээг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийг хялбар авах боломжоор хангана.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	-	УЦУОШ А
87		Сүмбэр сумын гэр хороолол, Найрамдал хотхонд агаарын чанарын бохирдлын сорьц, Хаялга нуурын уснаас дээж авах харуулын цэг байгуулна.	Шинээр байгуулах харуулын цэгийн тоо Агаарын давхар исэл болон хүхэрлэг хий, усны ионы хэмжээг тодорхойлох боломжоор хангагдана.	3 100 хувь	АОНХС 30.0	УЦУОШ А
88		Нийтийн эзэмшлийн талбайд мод тарьж бичил цэцэрлэг байгуулна.	Шинээр байгуулсан болон нөхөн сэргээсэн бичил цэцэрлэгийн тоо Модны тоо	1 1000-аас доошгүй	-	СЗДТГ, БОАЖГ, Ойн анги
89	Ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх, замаар байгаль орчны доройтлыг сааруулах.	Авто замын дагуух ойн зурваст услалтын систем, ус нөөцлөх сав суурилуулна.	Ус нөөцлөх сав Услалтын шугам хоолой Мод, бутны ургалт, амьдралтын хувь	4 3000 м-ээс доошгүй 70 хувиас дээш	БХНСАХЗ 25.0	БОАЖГ, Ойн анги
90		Туурь балгас, хур хог хаягдлыг цэвэрлэнэ.	Цэвэрлэх талбайн хэмжээ	5 га	-	СЗДТГ, БОАЖГ

91		Авто замын дагуу болон төвийн ногоон байгууламжид услалын систем байгуулах, хөв цөөрөм байгуулах ажлын зураг, төсөв боловсруулах	Зураг төвийн гүйцэтгэл	100 хувь	БХНСАХЗ 10.0	БОАЖГ
92		Найрамдал хотхоны нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна талбайг зүлэгжүүлэх, услалтын шугам хоолой суурилуулах.	Ногоон байгууламжийн хэмжээ	0,5 га	БХНСАХЗ 19.0	БОАЖГ, Ойн анги
93		Найрамдал хотхоны орон сууцны гаднах зүлэгжүүлсэн талбайг хашаажуулах.	Хашааны хэмжээ	577 м <sup>2</sup>	БХНСАХЗ 25.0	БОАЖГ, Ойн анги
<b>4.2 Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах чиглэлээр</b>						
94	Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах.	Гол горхи, булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах, хөв цөөрөм байгуулах.	Шинээр хамгаалсан булаг, шандны тоо Хөв цөөрөм байгуулах	1 1	БХНСАХЗ 57.8	СЗДТГ, БОАЖГ
95		Баянтал сумын ундны усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтанд авч, тэжээгдлийн мужаар тэмдэгжүүлэн, эрүүл ахуйн дэглэм мөрдүүлнэ.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	БХНСАХЗ 2.0	БОАЖГ
96	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах.	Монгол тарвага сэргээн нутагшуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Нутагшуулах тарваганы тоо	50	БХНСАХЗ 18.0	БОАЖГ
<b>4.3 Байгаль хамгаалах ажилд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр</b>						
97	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулахад олон нийтийн оролцоог хангах.	Мод, бут тарьсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.	Таригдсан модны тоо Иргэдийн оролцоо нэмэгдсэн хувь хэмжээ	2000-аас доошгүй 1.5 дахин нэмэгдэнэ.	БХНСАХЗ 12.9	СЗДТГ, БОАЖГ
98		Хууль бус ан агнуур, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулах	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	БХНСАХЗ 2.5	БОАЖГ
99		Рашаан болон рашаан төст ус, шаврын найрлагын судалгаа хийлгэх. /Цоорхой, Хүрийн ногоон/	Судалгааны ажлын гүйцэтгэл	100 хувь	БХНСАХЗ 0.5	БОАЖГ
100		Тогтвортой хөгжлийн боловсрол олгох төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	БХНСАХЗ 3.0	СЗДТГ, БОАЖГ, БСУГ, ТББ, Нөхөрлөл
<b>4.4 Аялал жуулчлалын салбар</b>						
101	Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, менежментийг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлэх.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжүүлэх.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт Жуулчдын тоо	100 хувь Өмнөх оноос 15 хувиар нэмэгдсэн байна.	АОНХС 23.0	БОАЖГ
102		Тусгай хамгаалалттай газар нутаг болон аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэг байгуулна.	Хогын савны тоо Сайжруулсан бие засах газар	6 2	БХНСАХЗ 15.9	БОАЖГ, СЗДТГ
103		Улсын чанартай авто зам, аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэг байгуулна.	Шинээр байгуулах түр буудалах цэгийн тоо	1	АОНХС 8.0	БОАЖГ, СЗДТГ
104		Жуулчны бааз, отог байгуулахыг бодлогоор дэмжиж, гадаад, дотоодын аялагчдыг хүлээн авах.	Байгуулагдсан бааз, отгийн тоо Хүлээн авсан жуулчдын тоо	2 100-аас доошгүй	-	БОАЖГ, ГХБХБГ
105		Аймгийн биологийн төрөл зүйлийн судалгаанд үндэслэн фото зургийн цомог хийлгэнэ /амьтан, ургамал/	Цомгийн тоо	1000	БХНСАХЗ 17.0	



**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

**5.1 Тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэх чиглэлээр**

106	Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг ханган, төрийн албыг чадавхижуулж, ёс зүйг дээшлүүлж, хариуцлагыг нэмэгдүүлэх.	Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	АЗДТГ
107		Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл, мэргэжил, ур чадварыг дээшлүүлж чадавхижуулна.	Зохион байгуулсан сургалтын тоо Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо	3-аас доошгүй 300-аас доошгүй 100 хувь	-	АЗДТГ
108	Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэх.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнах, иргэдээс санал авч үр дүнг үнэлэх ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа 2 дахин багассан байна.	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Санал асуулгад оролцсон өрхийн эзлэх хувь Зохион байгуулсан уулзалт	10 хувиас багагүй 1-ээс доошгүй	ОНТ	АЗДТГ, СЗДТГ
109		Аймгийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивыг цахимжуулж, нэгдсэн системд холбох ажлын хүрээнд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг суурилуулж, сүлжээнд холбон, цахимжуулна.	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	УТХО 4.0	АЗДТГ, УБХ, МТС ТӨХК
110		Мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэжээ	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл	100 хувь	АОНХС 20.0	
111		Төрийн архивын хадгалалт, хамгаалалтын нөхцлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	100 хувь	ОНТ 13.2	АЗДТГ
112	Төрийн худалдан авалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.	Цахимаар зохион байгуулсан худалдан авалтын хувь	100 хувь	-	ОНӨГ	
<b>5.2 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр</b>						
113	Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх.	Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 10.0	АЗДТГ
114		Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	10-аас доошгүй	АОНХС 24.5	ОБГ, СЗДТГ
115		Цэргийн болон улсын дайчилгааны даалгаврын хэрэгжилтийг сайжруулна.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	-	АЗДТГ, СЗДТГ
<b>5.3 Гадаад харилцааны салбар</b>						
116	Аймгийн гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх.	Аймгийн гадаад харилцааг салбараар хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	100 хувь	АОНХС 20.0	АЗДТГ